



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 27 ,

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Бууцагаан сумын ИТХ-ын төсвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад Бууцагаан сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017.12.21-ны өдрийн А/43 тогтоолоор Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох тэтгэмжийн зардал 5011600 төгрөгийг сумын ИТХ-ын төлөөлөгчдийг тойрогтоо ажиллах, хууль тогтоомж сурталчилах зардалд 21 төлөөлөгчид тус бүр 238648 төгрөгийг олгох шийдвэр гарган олгожээ.

Дээрх зөрчил дутагдал гаргасан нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2 б дэх заалт мөн Төсвийн тухай хуулийн 41.2.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх..., Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь "...төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зориулалт бусаар зарцуулсан 5011600 / Таван сая арван нэгэн мянга зургаан зуун/ төгрөгийг холбогдох хүмүүсээс авч Бууцагаан сумын Орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэх.

D:\2018 on akt\Buutsagaan sumiin ITH_akt .docx

2517083

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2017 оны 04 дүгээр сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Бууцагаан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Д.Эрдэнэдалай, нягтлан бодогч Д.Баярмаа нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН ¹ :	ЗӨВШӨӨРСӨН:
АХЛАХ АУДИТОР  А.ЦЭЭНЯМ	БУУЦАГААН СУМЫН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  Д.ЭРДЭНЭДАЛАЙ НЯГТЛАН БОДОГЧ Д.БАЯРМАА

6417143544
0A0067 9007423

6415 109546

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 28

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Бууцагаан сумын ЗДТГ-ын төсвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад Сумын ЗДТГ-ын даргын 2017.12.21-Б/12 тушаалаар сахилгын шийтгэлтэй 4 ажилтанд 1200.0 мянга, Сумын ЗДТГ-ын даргын 2017.12.21-Б/12 тушаалаар Засаг дарга Ж.Алтанцэцэгт аймгийн Засаг даргын шийдвэр гараагүй байхад 300.0 мянган төгрөгийг олгосон байна.

Дээрх зөрчил дутагдал гаргасан нь Монгол Улсын Их Хурлын 2017 оны “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны “Урамшуулал олгох тухай” 52 дугаар тэмдэглэлийг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх..., Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь “...төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан” зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зориулалт бусаар олгосон 1350000 / Нэг сая гурван зуун тавин мянган/ төгрөгийг холбогдох хүмүүсээр төлүүлж Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх.

D:\2018 on akt\Buutsagaan sumiin ZDTG_akt - .docx

2517085

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2017 оны 04 дүгээр сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Бууцагаан сумын ЗДТГ-ын дарга Д.Лхагвадорж, нягтлан бодогч Д.Баярмаа нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН ¹:

АХЛАХ АУДИТОР  А.ЦЭЭНЯМ

ЗӨВШӨӨРСӨН:

БУУЦАГААН СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГА  Д.ЛХАГВАДОРЖ
НЯГТЛАН БОДОГЧ
 Д.БАЯРМАА



¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 29

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Бууцагаан сумын ЗДТГ-ын төсвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад

1. "Баян тойром" ХХК, "Хонгор майнинг" ХХК-аас авах газрын төлбөрийн орлогын 800.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд гэрээ хийж авсан мөн "Хонгор хангайн эрдэнэс" ХХК-аас нөхөн сэргээлтийн барьцаанд 500.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд байршуулж хөрөнгийг ЗДТГ-ын үйл ажиллагааны зардалд тус тус зарцуулсан байна.
2. Сумын уурын зуухыг түрээслэгч Өлзийт нөмөрт хайрхан хоршооноос орох түрээсийн орлого 350.0 мянган төгрөгийг дутуу авч тайланд авлагаар тусгаагүй байна.

Дээрх зөрчил дутагдал гаргасан нь Татварын ерөнхий хуулийн 7.4.11 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 41.2.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гаргах гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх..., Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь "...төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

D:\2018 on akt\Buutsagaan sumiin ZDTG_akt 2.docx

2517087

1. Төсөвт дутуу оруулсан орлогын 350,0 мянган төгрөгийг Өлзийт нөмөрт хайрхан хоршоогоор, зориулалт бусаар зарцуулсан газрын төлбөр 800,0 мянган төгрөгийг төсвөөс тус тус төлүүлж Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Зориулалт бусаар зарцуулсан Нөхөн сэргээлтийн барьцааны 500,0 мянган төгрөгийг сумын Орон нутгийн орлогын дансанд байршуулах.
3. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2017 оны 04 дүгээр сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Бууцагаан сумын ЗДТГ-ын дарга Д.Лхагвадорж, нягтлан бодогч Д.Баярмаа нарт хариуцуулав.

АКТЫГ


ТОГТООСОН¹:

АХЛАХ АУДИТОР  А.ЦЭЭНЯМ



ЗӨВШӨӨРСӨН:

БУУЦАГААН СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГА  Д.ЛХАГВАДОРЖ
НЯГТЛАН БОДОГЧ



Д.БАЯРМАА

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.